



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№43 /257/

2022.03.03

Цаг үе, үйл явдал

ТӨРИЙН ОДОН МЕДАЛЬ ГАРДУУЛЛАА



Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын зарим ахмадыг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шагналаа. Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан өнөөдөр БХЯ-наа шагналыг гардуулан өгсөн юм. Ёслолын ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын

сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Тогоо, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч бригадын генерал Х.Лхагвасүрэн, ЦЕГ-ын дэд дарга цагдаагийн хурандаа О.Амарсана болон Монгол цэргийн нэгдсэн холбооны төлөөлөл, шагнагдсан ахмадууд байлцав.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Монгол Улсын аюулгүй байдал тусгаар тогтнолыг хамгаалах үйлсэд залуу халуун нас, оюун ухаан, эрдэм мэдлэг, ур чадвар, хөдөлмөр зүтгэлээ харамгүй зориулсан эрхэм хүндэт ахмад дайчид та бүхэндээ удахгүй тохиох Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярын дайчин цогтой халуун мэндийг өргөн дэвшүүлэе. Эл өдөр бол Монгол Улсын хувьд томоохон тэмдэглэлт баяруудын нэг. Цэрэг эрсээ хүндэтгэж, тэднийхээ

байгуулсан гавьяа үйл хэргийг бататгаж ирсэн сайхан өдөр. Өнгөрсөн жил бид цар тахалтай байсан учраас Зэвсэгт хүчнийхээ 100 жилийн ойг төдийлөн өргөн дэлгэр тэмдэглэж чадаагүй. Энэ жилийн тухайд 100, 101 жилийн ойн баярын ёслолын арга хэмжээ явагдана. Юуны өмнө Монгол Улс, дархан хил аюулгүй байгаагийн баталгаа нь эх орон, төр ард түмэндээ тангараг өргөсөн эрхэм ахмад дайчид та бүхний хөдөлмөр зүтгэлийн нэгээхэн үр дүн гэдгийг хэлэх нь зүйтэй. Орчин цагийн Зэвсэгт хүчин маань 100 нас давлаа. 100 жилийн түүхтэй Зэвсэгт хүчин, аюулгүй байдлын салбартай улс орон дэлхийд цөөн. Өнөөдөр та бүхэн Монгол Улсын Батлан хамгаалах яаманд ирж төрийн одон медалиа гардан авсанд баяртай байна. Таны, та бүхний хань ижил, гэр бүл, үр хүүхдүүдэд баяр хүргэж, аз жаргал эрүүл энхийг хүсэн ерөөе. Дархан хил ариун дагшин байж, Монгол Улс маань хөгжин мандаж, бадрах болтугай хэмээн ерөөе" гэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-24

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,880.00	2,888.0
EUR	3,225.0	3,245.0
CNY	455.00	456.00
RUB	32.00	36.50
JPY	24.95	25.10
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ



ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

НАС АХАР БОЛНО

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.30-18.39

БАРИЛДЛАГА:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сэтгэй газар очих, уул овоо тахирад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад сохиромжгүй.

"ХУРАНДАА-1" БАГ ХОШУУЧЛАВ



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүний дунд "Цол бүхэн сайхан" тэмцээнийг энэ сарын 1, 2-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээ буудлага, гар бөмбөг гэсэн 2 төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд тэмцээнд БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүнээс бүрдсэн генерал, хурандаа, дэд хурандаа, хошууч, ахмад, ахлах дэслэгч, дэслэгч, ахлагч гэсэн 10 баг оролцлоо.


Ингээд буудлагын тэмцээнд 10 багийн 60 гаруй тамирчин гар буу, автомат бууны тогтоол, тактикийн буудлагын төрлөөр өрсөлдсөнөөс 1 дүгээр байрт хурандаа Д.Дугаррагчаа ахлагчтай "Хурандаа-1" баг 12 оноогоор, 2 дугаар байрт хошууч Ц.Ринчин ахлагчтай "Хошууч" баг 12 оноогоор, 3 дугаар байрт ахмад Б.Энхмагнай ахлагчтай "Ахмад" баг 18 оноогоор тус тус шалгарсан юм.

Гар бөмбөгийн тэмцээнд тэмцээнд 10 багийн 80 гаруй тамирчин өрсөлдсөнөөс 1 дүгээр байранд хошууч Б.Сергей ахлагчтай "Хошууч" баг, 2 дугаар байрт, хурандаа Д.Цог-Эрдэнэ ахлагчтай "Хурандаа-1" баг, 3 дугаар байрт ахлах дэслэгч Д.Цагаанбаяр ахлагчтай "Ахлах дэслэгч" баг тус тус шалгарсан.

Тэмцээний нийлбэр дүнгээр 1 дүгээр байрт хурандаа Д.Цог-Эрдэнэ ахлагчтай "Хурандаа-1" баг 3 оноогоор, 2 дугаар байрт хошууч Г.Мөнхбаяр ахлагчтай "Хошууч" баг 3 оноогоор, 3 дугаар байрт ахмад Б.Энхмагнай ахлагчтай "Ахмад" баг 8 оноогоор тус тус эхний байруудад шалгарлаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг тус тэмцээнд анх удаа БХЯ-ны удирдлага, бие бүрэлдэхүүн оролцсон нь ихээхэн онцлогтойн дээр тэмцээнийг улам илүү өрсөлдөөнтэй болгож байлаа. Түүнчлэн буудлагын тэмцээнийг тактикийн буудлагын ангиллыг нэмж оруулан өрсөлдсөн нь тамирчдын ур чадварыг илтгэж байлаа.

НЭГТГЭЛ, АНГИУДЫН ПОЛИГОНЫ ДАДЛАГА ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилийн нэгдүгээр үе төгсөх шатандаа орж нэгтгэл, анги, салбарууд хээрийн гаралт /полигоны дадлага/-аа зохион байгуулж, үндсэн салбаруудынхаа жигдрэлтийг хангаж байна.

Хээрийн гаралтын төгсгөлд нэгтгэл, ангиуд байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль болон тусгай тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулан явуулж, үндсэн салбаруудынхаа үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшнээ тогтооно.

Энэ сургуулийн жилд байлдааны нэгтгэл, анги, салбаруудаас гадна төрөл мөргэжлийн бүх анги, салбарууд үндсэн үүргийнхээ хүрээнд явуулж

буй тусгай тактикийн хээрийн сургуулийнхаа сэдэв, зохион байгуулалттай уялдуулан байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг төлөвлөн явуулж, үүрэг гүйцэтгэх чадавхаа дээшлүүлж байгаагаараа онцлог юм. Мөн нэгтгэл, ангиудын хээрийн гаралтын бэлтгэл, явц байдал, зарим салбаруудын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуультай Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлагын хамтарсан туслах ажлыг зохион байгуулж байна. Нэгтгэл, анги, салбаруудын хөгжүүлэх шатны сургалт 4 дүгээр сараас эхэлнэ.

Дэд хурандаа А.БАТСҮХ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,271,724 /69.8%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,173,135 /66.8%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,025,368 31,5% 105,671 /3,2%!
--	---	--

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8327 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 113	ЭДГЭРСЭН 8095
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 440,661,219

Эдгэрсэн

Нийт: 373,162,657

Нас барсан

Нийт: 5,993,167

ЭРЧҮҮДИЙН ИЛҮҮДЭЛ ЖИН БА ТАРГАЛЛАЛТ

Насанд хүрсэн хүн илүүдэл жин ба таргалалтыг тусгай бичигтэй илрээс (БЖИ)-ээр танинбарладаг. Насанд хүрсэн хүний БЖИ ≥ 25 кило байвал өгүүлдэг жин, БЖИ ≥ 30 кило бол таргалалттай гэж үзнэ.

ИЛҮҮДЭЛ ЖИН БОЛОН ТАРГАЛЛАЛТЫН ШАЛГАМ

Эрүүл бус буюу тургэн зоол, хүнсний харгалзаа хэмээн.

Гар орон болон ажилын байрнд суугаа хэв маяг давамгайлж, хөдөлгөөнийг хомсдолд орсон.

ТАРГАЛЛАМС ҮЭСЭ ХҮНДЭРЛҮҮ:

- Цусны даралт ихэснэ
- Чихрийн шижин ихэснэ
- Халдур
- Тархины эвдрэл
- Элэгний өвчлөл
- Төмөрний өвчлөл

МОНГОЛ УЛСАД

15-49 насны 2 зурвэгт тухайн 1 нь илүүдэл жинтэй эвсэл таргалалттай

Таргалалт 14,6% | Илүүдэл жин 34,2%

Эрчүүдийн дунд илүүдэл жин ба таргалалтын таргалалт нэмж буурсаа

15-19 нас - 17,7% | 20-29 нас - 33,2%
30-39 нас - 59,2% | 40-49 нас - 63,9%

Цахим шууданд

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд "Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад явагдсан Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр", "Тогтвортой эрх чөлөө" олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн "Нисдэг тэрэгний техник, засвар үйлчилгээний бүлгүүдийн туршлага, сургаж" сэдэвт хэлэлцүүлэг ангийн байрлалд зохион

байгуулагдлаа.

Хэлэлцүүлэгт ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, газрын даргын орлогч хурандаа Д.Дугаррагчаа, Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Н.Цогтгэрэл, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын захиргаа удирдлагын хэлтсийн дарга хурандаа Б.Баярсайхан, ангийн удирдлагууд болон 8 ээлжийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл

оролцож ажиллагааны өмнөх бэлтгэлийн онцлог, үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний судалгаа, ар тал, техникийн хангалтын байдал, сэтгэл зүйн бэлтгэлжилт, ажиллагааны газар оронд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулсан туршлага, сургаж, ажиллагааны онцлогийг харуулсан ном, зурагт альбом, дурсгалын буланг бүтээх зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг өрнүүлэв.

"ХИМИЙН ӨДӨР"-ӨӨР ...

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, "Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж явуулах тухай" ангийн захирагчийн тушаал,

долоо хоногийн товч, цагийн хуваарийн дагуу офицер, ахлагч нарын химийн бэлтгэлийн дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх норматив номер 1, 2, 3 а,б-г боловсруулж сургуулийн

дуурайлган үзүүлэх химийн хорт утаатай майханд оруулж, сургалт, дадлагыг чанартай зохион байгуулж явууллаа.

Ахмад Б.НАРАНБААТАР



ТАНИЛЦАХ ДАДЛАГЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Батлан хамгаалахын сайдын тушаалаар Үндэсний Батлан Хамгаалах их сургуулийг түшиглэн "Хүний хөгжлийн менежер" соёл хүмүүжлийн ажилтан, цэргийн сэтгэл зүйч бэлтгэх богино хугацааны мэргэщүүлэх сургалтад хамрагдаж буй суралцагчид өчигдөр Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцлаа.

Энэ хүрээнд ангийн түүхэн замнал,

хариулт өглөө.

Арга хэмжээний үеэр ЗХЖШ-ын Суртал хүмүүжил, мэдээлэл, сэтгэл зүйн хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан, мэргэжилтэн ахмад Б.Жавхлантөгс нар хүрэлцэн ирж, танилцах дадлагын суралцагчидтай зохион байгуулж буй үйл ажиллагаатай танилцав.

Суралцагчдад ангийн дайчин алдрын болон сэтгэл зүйн алжаал тайлах танхимын үйл ажиллагааг танилцуулж, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, хугацаат цэргийн алба



үндсэн үүргийн талаар танилцуулга, "Сэтгэл зүйн хангалтын төрлүүд, тэдгээрийн агуулга" сэдвээр сэтгэл зүйн хангалтын офицер ахлах дэслэгч Т.Дэлгэрмаа яриа таниулга хийж анги, салбарт сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах туршлага сургажгийн талаар ярилцаж, суралцагчдын сонирхсон асуултад

хаагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх талаар туршлага тусламжаа хуваалцлаа.

Мөн ЦДБЭЧ-ын Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга дэд хурандаа Р.Өнөржаргалыг урин "Хувь хүний маркетинг" сэдвээр сургалт зохион байгууллаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

ЭНЭ УДААГИЙН ХЭЭРИЙН ГАРАЛТААР...



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд мотобуудлагын ротын байлдааны буудлагыг "Хориглох байлдаан явуулах үеийн мотобуудлагын ротын ажиллагаа" сэдвээр бие бүрэлдэхүүнийг орон

тооны зэвсэг, техникээ бүрэн эзэмшиж, байлдааны үүрэг гүйцэтгэхэд сурган дадлагажуулах, гар нийлэмжтэй ажиллагааг ханган, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх зорилгоор ангийн буудлагын талбайд 3 үе шаттай зохион байгууллаа.

Мотобуудлагын ротод ангийн захирагчийн

тушаалаар томилгоожсон цэргийн алба хаагч бүрд сургуулийн буудлагын анхны дасгал №02, тасгийн байлдааны бэлтгэлийн буудлагын дасгал №01, бэлтгэлийн буудлагын дасгал №04-ийг тус тус сургалтын районд явуулж, тасаг, салаа, ротын жигдрэлтийг хангаж ажиллав.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ

ЗАРЛАЛ

ЦНДС-ийн Агаарын цэргийн тэнхимийн 30 жилийн ойн ажлын хүрээнд өөрийн төгссөн сургууль, хуучин нэрээрээ АДХЦ-ийн тэнхим, эзэмшсэн Зенит артиллери, Зенитийн пуужин, Радиотехник, Радиоэлектроник, Нисэхийн мэргэжлээрээ бахархсан 8 мөрт шүлгийн уралдааныг зохион байгуулж байна. Шүлгийг файлаар, болон бичгээр ирүүлж болно.


Уралдааныг 2022 оны 3 сарын 17-ны өдөр ҮБХИС-ийн ЦНДС, Агаарын цэргийн тэнхим дээр шалгаруулна. Зохиогч материалаа Dun-gaa.tse@gmail.com электрон хаягаар болон өөрийн биеэр хүргүүлэн ирэх, ирүүлэхдээ овог нэр, холбогдох утасны дугаараа бичиж явуулна уу.

АГААРЫН ЦЭРГИЙН ТЭНХИМ




Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

ЦАХИМ ХАЯГ



ЦАХИМ ХУУДАС



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)